



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 03

Баруун-Урт

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "а", 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гуравдугаар Хурлаас ТОГТООХ нь:

1. "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт"-ыг хавсралтаар баталсугай.

2. Үндсэн чиглэлийг Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга, холбогдох агентлаг, албадын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ХОСБАЯР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
.....03 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



СҮХБААТАР АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

НЭГ. ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ

Зорилго 1. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Үндэсний бахархал, эв нэгдэл, Нүүдлийн соёл иргэншилт Монгол

Зорилт 1.1. Үндэсний үнэт зүйлсийг хадгалж хамгаалан хойч үедээ өвлүүлэн уламжилна.

1.1.1 Хүүхэд залуусыг үндэсний өв соёл, зан заншлаа дээдлэгч, өвлүүлэгч, хамгаалагч иргэн болгож хөгжүүлнэ.

1.1.2 Угсаатны өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлнэ.

1.1.3 Аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээнэ.

1.1.4 "Дарьганга соёлын өв" брэнд, брэндбүүк бүтээн, соёл урлагийн болон сурталчилгааны контент бүтээх, олон нийтэд сурталчлах, сувгийн хөгжүүлэлт хийнэ.

1.1.5 "Сүхбаатар аймаг" брэнд, брэндбүүк бүтээн, соёл урлагийн болон сурталчилгааны контент бүтээх, олон нийтэд сурталчлах, сувгийн хөгжүүлэлт хийнэ.

Монгол хэл бичиг

Зорилт 1.2. Үндэсний Монгол хэл бичгээ хэрэглэж хэвшинэ.

1.2.1 Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

Соёл урлагийн үйлчилгээ

Зорилт 1.3. Соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.1. Соёл, урлагийн байгууллагын чадавхыг сайжруулна.

1.3.2. Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай иргэнийг төлөвшүүлж, гэр бүлийн боловсролыг дээшлүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Боловсрол

Зорилт 2.1. Сургууль, цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, боловсролын чанарт ахиц гаргана.

2.1.1 Хөдөө сумдын сургууль, цэцэрлэг дэх шаардлагатай мэргэжлийн багшийн хангамжийг нэмэгдүүлнэ.

2.1.2 Багшийн ажлын ачааллыг багасган нэг багшид ногдох хүүхдийн тоог бууруулна.

2.1.3 Орон нутгийн хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэг, дотуур байрын хангамжийг нэмэгдүүлж барилгыг стандартын шаардлагад нийцүүлнэ.

Зорилт 2.2. Боловсролын байгууллагад хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.

2.2.1 Суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлж сурах хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 2.3. Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан олгох сургалтын хүртээмж, чанарыг сайжруулна.

2.3.1 Насан туршийн боловсрол төвийг мэргэжлийн мэргэшсэн багшаар хангана.

2.3.2 Зорилтот бүлгийн иргэдэд боловсрол олгож амьдрах чадварыг дээшлүүлнэ.

Эрүүл мэнд

Зорилт 2.4. Эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж дундаж наслалтыг уртасгана.

2.4.1 Халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээний хамрагдалтыг нэмэгдүүлж сэргийлж болох нас баралтын түвшнийг бууруулна.

2.4.2 Халдварт өвчний түвшнийг бууруулна.

2.4.3 Эхийн эндэгдэлгүй ажиллаж нялхсын эндэгдлийг бууруулна.

2.4.4 Нэн шаардлагатай хүний нөөцийн хангалт, чадавхыг нэмэгдүүлнэ.

2.4.5 Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

2.4.6 Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, зайлшгүй шаардлагатай эмийн хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтыг цахимжуулна.

Зорилт 2.5. Эрүүл мэндийн байгууллагуудад үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

2.5.1 Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын шинэчлэл, засвар үйлчилгээг сайжруулна.

2.5.2 Яаралтай тусламжийн автомашины парк шинэчлэлийг нэмэгдүүлнэ.

2.5.3 Техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж хангалтыг нэмэгдүүлнэ.

2.5.4 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна.

Зорилт 2.6. Гэр бүл, хүүхэд залуучуудыг соён гэгээрүүлж гэр бүлийн боловсролыг дээшлүүлнэ.

2.6.1 Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.2 Залуучуудын хөгжлийг дэмжинэ.

2.6.3 Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.4 Ахмад настанд үйлчлэх хөгжлийн ордон, танхимын тоог нэмэгдүүлнэ.

Хүнд ээлтэй амьдрах орчин

Зорилт 2.7. Иргэдэд ээлтэй, аюулгүй амьдрах, баталгаат орчныг бий болгоно.

2.7.1 Хүнсний аюулгүй байдлын баталгааг хангана.

2.7.2 Хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг сайжруулна.

2.7.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

2.7.4 Аймгийн төвийн болон сумдын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг үе шаттайгаар барина.

2.7.5 Аймгийн хэмжээний барилгуудыг паспортжуулах, гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлж иргэдийн аюулгүй амьдрах баталгааг хангана.

2.7.6 Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэлтийг тогтоож барилгын чанарыг дээшлүүлнэ.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж орон сууцны хангамжийг өсгөн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл

Зорилт 3.1. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж аймгийн хэмжээнд татварт бүртгэлтэй ажил олгогчийн 98, эдийн засгийн идэвхтэй хүн амын 50 хувийг нийгмийн даатгалд, нийт хүн амын 98 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулна.

3.1.1 Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тэдгээрийг дагалдан гарах журам, дүрмийг иргэдэд сурталчлах, сургалт сурталчилгааг сайжруулна.

3.1.2 Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.3 Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын нөхөн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес

Зорилт 3.2. Хөдөлмөрийн эрхлэлтийг нэмэгдүүлж өрхийн орлогыг өсгөнө.

3.2.1 Бизнес эрхлэгчдэд бүх төрлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, бизнес инкубаторын үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.2.2 Орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, хоршоодын бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог кластерын системээр хөгжүүлнэ.

3.2.3 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.

3.2.4 Хөдөлмөрийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхол, хандлагыг нэмэгдүүлнэ.

Орлогод нийцсэн орон байр

Зорилт 3.3. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцаар хангана.

3.3.1 Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.3.2 Гэр хорооллыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбоно.

3.3.3 Орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Зорилт 3.4 Иргэдийг спортын олон төрлөөр хичээллэх нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.

3.4.1 Үндэсний спортыг хөгжүүлнэ.

3.4.2 Өсвөр үе, залуучуудыг спортын олон төрлөөр хичээллэж бие бялдраа хөгжүүлэх, спортын амжилтыг ахиулах нөхцөл боломжоор хангана.

3.4.3 Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлнэ.

Газрын харилцаа, барилга хот байгуулалт

Зорилт 3.5. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын бодлогыг уялдуулан хэрэгжүүлж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна.

3.5.1 Аймгийн хэмжээнд хаягжилтын нэгдсэн системийг бүрдүүлнэ.

3.5.2 Газар өмчлөлийг эрчимжүүлнэ.

3.5.3 Нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зурагтай болгоно.

3.5.4 Сум, суурин газрын хот төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллана.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

Зорилго 4. Орон нутгийн эдийн засгийн өсөлтийг тогтвортой дээшлүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Чинээлэг монгол

Зорилт 4.1. Аймгийн төсвийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглэсэн үр ашигтай, хариуцлагатай зарцуулна.

4.1.1 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.1.2 Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.1.3 Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож сахилга хариуцлагыг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

4.1.4 Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

4.1.5 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.

Зорилт 4.2. Боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

4.2.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж малын гаралтай бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

4.2.2 Шинэ технологи, инновацийн ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлнэ.

4.2.3 Оюуны өмчийн патент, чанар стандартын баталгаатай орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.

4.2.4 Экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.2.5 "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих" төслийн хүрээнд ХАА-н түүхий эд боловсруулах төвийг байгуулж ХАА-н бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлнэ.

4.2.6 Уул уурхайн орд газрыг түшиглэн экспортод чиглэсэн хүнд үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

4.2.7 Олон улсын тээвэр логиستيкийн төв байгуулна.

4.2.8 Сүхбаатар хөгжил УТП-ын үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Ухаалаг санхүүгийн зах зээл

Зорилт 4.3. Олон талт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.3.1 Иргэн хуулийн этгээдэд хөрөнгийн зах зээл бусад үүсмэл санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг хүргэж мэдлэгийг дээшлүүлнэ.

4.3.2 Даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ТАВ. ЗАСАГЛАЛ

Зорилго 5. Цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, хүний эрхийг хангасан, шударга ёс төлөвшсөн, авлигагүй аймаг болно.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Ухаалаг засаглал

Ухаалаг бүтэц

Зорилт 5.1. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэй болгоно.

5.1.1 Төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшлийн санал оролцоог хангах, мэдээлэл солилцох боломж бүхий нэгдсэн цахим программ нэвтрүүлнэ.

5.1.2 Сумдын ЗДТГ-т "ISO 9001:2015" олон улсын Чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлнэ.

5.1.3 Төрийн байгууллагын ажиллах нөхцөл, техник, технологийг сайжруулна.

Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба

Зорилт 5.2. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, ёс зүйтэй, тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ.

5.2.1 Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулна.

5.2.2 Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангаж тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүний эрхийг дээдэлсэн нийгэм

Зорилт 5.3. Хүний эрхийг дээдэлсэн хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчил шийдвэрлэлтийн хувийг нэмэгдүүлнэ.

5.3.1 Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг дээдлэх хандлага, дадлыг төлөвшүүлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.

5.3.2 Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, оролцогчдод үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж, эрхийг нь хамгаалахад мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

Авлигагүй засаглал

Зорилт 5.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, шударга ёсыг эрхэмлэхэд иргэдийн хандлагыг дээшлүүлж, төрийн байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлнэ.

5.4.1 Орон нутгийн төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод, хариуцлагатай байдал, авлигыг хянах дотоод хяналтын механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.

5.4.2 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, шударга ёсыг эрхэмлэхэд иргэдийн хандлагыг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулна.

ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ

Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулна.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Эх байгаль анхдагч экосистем

Зорилт 6.1. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн талаарх боловсролыг дээшлүүлнэ.

6.1.1 Иргэдэд байгаль хамгаалах, ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулна.

6.1.2 Тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлнэ.

Байгалийн баялгийн үр өгөөж

Зорилт 6.2. Цөлжилтийг бууруулна.

6.2.1 Доройтсон талбайг нөхөн сэргээнэ.

6.2.2 Төв суурин газрын ногоон байгууламжийн ургалтын хувь болон ойн сан бүхий газрын ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

6.2.3 Ховордсон биологийн төрөл зүйлийн нөөцийг хамгаалж, сэргээн нутагшуулна.

Үнэт баялаг ус

Зорилт 6.3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, суурин хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усаар 100% хангана.

6.3.1 Усны сан бүхий газар болон ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн дэглэмийг сайжруулж хамгаалалтын бүс тогтооно

6.3.2 Ус хуримтлуулах хөв цөөрөм, усан сан байгуулна.

6.3.3 Аймаг, сумын төвийн хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усаар хангах зорилгоор ундны усны эх үүсвэрт ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулна.

Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

Зорилт 6.4. Агаар, орчны бохирдлын түвшнийг бууруулна

6.4.1 Агаарын чанарыг хэмждэг багаж тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж агаарт агуулагдаж буй 4-5 төрлийн элементийг хэмждэг болно.

6.4.2 Хатуу хог хаягдлыг ангилж дахин боловсруулалт хийнэ.

6.4.3 Аймгийн хэмжээний нүхэн жорлонгийн тоог бууруулж хөрсөнд нэвчдэггүй эко жорлонг аялал жуулчлалын бүс нутагт суурилуулна.

ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Зорилго 7. Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Зэвсэгт хүчин

Зорилт 7.1. Дайчилгааны бэлэн байдлыг ханган иргэн цэргийн харилцааг бэхжүүлж улсын батлан хамгаалах эрх ашигт нийцсэн орон нутгийн хамгаалалтыг сайжруулна.

7.1.1 Дайчилгааны томилгоот бүрэлдэхүүнийг чадавхжуулна.

7.1.2 Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулна.

7.1.3 Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах, сургалт явуулах болон нөөц бүрдүүлнэ.

Дархан хил

7.1.4 Хилийн торон саадны бүрэн бүтэн байдлыг хангана.

Хүн, нийгмийн амар тайван байдал

Зорилт 7.2. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ

7.2.1 Орон нутгийн гамшгаас хамгаалах техник тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

7.2.2 Байгалийн гамшгийг даван туулах, тэдгээрт дасан зохицох чадавхыг бэхжүүлнэ.

Хууль сахиулах салбарын хөгжил

Зорилт 7.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж илрүүлэлтийг улсын дунджаас дээш түвшинд хүргэнэ.

7.3.1 Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг өргөжүүлнэ.

7.3.2 Мал хулгайлах гэмт хэргийг иргэдийн оролцоо, дэвшилтэт технологи ашиглан илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

7.3.3 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог хангана.

НАЙМ. БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Зорилго 8. Гадаад хамтын ажиллагааг бүсийн хэмжээнд хамтран өргөжүүлж өрсөлдөх чадварыг сайжруулах стратегийн дэд бүтцийг түшиглэн бүс орон нутгийн хөгжлийг хурдасгана.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Бүс нутгийн хамтын ажиллагаа

Зорилт 8.1. Зүүн хойд Азийн улс орнууд, хил залгаа бүс нутаг болон гадаадын төсөл хөтөлбөрүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

8.1.1 "Их түмэн санаачилга" бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд зүүн бүсийн хэмжээнд хамтран оролцоно.

8.1.2 ОХУ-ын хил орчмын муж хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

8.1.3 БНХАУ-ын муж хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

8.1.4 Хамтын ажиллагааны хүрээнд орон нутагт оруулах гадаадын хөрөнгө оруулалтын тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

8.1.5 Зүүн бүсийн хүрээнд аялал жуулчлал, хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон төслүүдэд хамтран ажиллана.

Зорилт 8.2. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн стратегийн дэд бүтцийг хөгжүүлнэ.

8.2.1 Баруун-Урт-Бичигт чиглэлд цемент бетон хучилттай их даацын 272 км авто зам барина.

8.2.2 Дорноговь аймгийн Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлнэ.

8.2.3 Бичигт боомтыг орчин үеийн стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.

8.2.4 Мэдээлэл холбооны суурь дэд бүтцийг өргөтгөнө.

Баруун-Урт хотын хөгжил

Зорилт 8.3. Баруун-урт хотын дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулна.

8.3.1 Нисэх буудлын үйл ажиллагааг өргөжүүлж, УБ-Баруун-Урт чиглэлийн нислэгийг сэргээнэ.

8.3.2 Авто зам, замын байгууламжийг өргөтгөн шинэчилнэ.

8.3.3 Гэрэлтүүлгийг нэмэгдүүлж ашиглалтыг сайжруулна.

8.3.4 Нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлнэ.

8.3.5 Аймгийн төвд байрлах аж ахуйн нэгж, байгууллагуудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбоно.

Зорилт 8.4. Баруун-Урт хотыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлнэ.

8.4.1 Дэд төвийг байгуулна.

8.4.2 1500 айлын хороолол төслийг хэрэгжүүлнэ.

8.4.3 Баруун-Урт хотод иргэдийн амрах, зугаалах газар, бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

8.4.4 Цахилгаан, дулааны эрчим хүчний өргөтгөл, шинэчлэлтийг хийнэ.

Сумдын хөгжил

Зорилт 8.5. Сумдыг орчин үеийн стандартад нийцсэн инженерийн болон нийгмийн дэд бүтэцтэйгээр хөгжүүлж, иргэд ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна.

8.5.1 Сумдыг төвлөрсөн ус, дулаан, ариутгах татуургын шугам сүлжээ, ариун цэврийн байгууламжтай болгон хөгжүүлнэ.

8.5.2 Сумын төвүүдийг ахуйн үйлчилгээний төвтэй болгоно.

8.5.3 Аймгийн төвийг сумдын төвүүдтэй хатуу хучилттай авто замаар холбоно.

8.5.4 Сумдын төвийн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөнө.

8.5.5 Алслагдсан сумдад агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ, ерөнхий зориулалтын нислэг үйлдэх зурвас газрыг тогтоож, хамгаалалтад авна.

8.5.6 Хот, сум хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

8.5.7 Хөдөөд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлнэ.

8.5.8 Өсөн нэмэгдэж буй хэрэгцээтэй уялдуулан цахилгаан дамжуулах агаарын шугамыг өргөтгөнө.

8.5.9 Хээрийн сайт барьж үүрэн холбооны сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Аялал жуулчлал

Зорилт 8.6. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

8.6.1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулна.

8.6.2 Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааг өргөжүүлнэ.

8.6.3 Аялал жуулчлалын бүс нутагт орчны бохирдлыг бууруулах нэгдсэн менежментийг бий болгоно.

Тогтвортой хөдөө аж ахуй

Зорилт 8.7. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг

эрчимжүүлж, чанар, бүтээмжийг дээшлүүлнэ.

8.7.1 Орон нутагт үйлдвэрлэсэн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах хангалтыг нэмэгдүүлнэ.

8.7.2 Бэлчээрийн менежментийг сайжруулан усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлнэ.

8.7.3 Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний ажлыг сайжруулж, малын чанар, ашиг шимийг дээшлүүлнэ.

8.7.4 Тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулна.

8.7.5 Малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

8.7.6 Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

8.7.7 Өвөл зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ

Зорилт 8.8. Малын гоц халдварт, халдварт, зоонози, халдваргүй өвчний гаралтыг бууруулна.

8.8.1 Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, тайван бүсийг тогтооно.

8.8.2 Малын халдварт, шимэгчтэх, зооноз өвчний гаралт, тархалтын байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, зарим өвчнөөр тайван байдлыг сум, нутгаар нь баталгаажуулна.

8.8.3 Халдваргүй өвчнийг хяналтад авна.

8.8.4 Мал эмнэлгийн лабораторийн чадавх, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

8.8.5 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд стандартыг мөрдүүлнэ.

---oOo---